



Сорилтыг Давах нь

МАГТААЛ ХҮНДЛЭЛ Бид Их Эзэнийг магтан хүндлэхдээ баяртай байдаг.

Унших Зүйл

Даниел 1; *Зөнчид ба Хаад*, х. 479-490.

Цээжлэх Ишлэл

"Бурууд татгалзаж зөвийг сонго" (Исаиа 7:15).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Зөв сонголтыг хийснээрээ Их Эзэнийг алдаршуулдаг гэдгийг **мэдэх** болно.
Сонгосон сонголтондоо **хариуцлагатай** байх болно.
Өөртөө сайн зүйлийг **сонгодог** болно.

Гол Санаа



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Даниел болон түүний найзууд баривчлагдан Небухаднезарын ордонд хүчээр амьдрах болжээ. Хааны тансаг зоогноос тэдэнд өгөхөд тэд харин энгийн зоог авч байхаар шийджээ. Тэд хааны үйлчлэгчээс хүч тэнхээ оруулдаг зоогийг асуухад үйлчлэгч нь тэднийг 10 хоног ногоотой хоол идэхийг зөвшөөрчээ. 10 хоногийн дараа Даниел болон түүний нөхөд нь хааны ширээнээс зоог барьж дарс ууж байсан олзлогдсон ямар ч хүмүүсээс илүү эрүүл саруул харагдах болов.

Тэд өөрөө өөрсөддөө хамгийн сайн зүйлийг сонгожээ.

Энэ бол магтаал хүндлэлийн тухай хичээл

Зөв сонголт хийснээрээ бид өөрсөддөө болон Их Эзэнд анхаарал тавьж байгаагаа Их Эзэнд харуулж байдаг. Бидний эрүүл мэндэд сайн зүйлсийг бид идсэнээрээ өөрсдийн биеэ эрүүл саруул байлгаж Их Эзэнийг хүндэлж байдаг. Их Эзэн биднээс аливаа зүйлийг хийхдээ үргэлж зөвийг сонгож байхыг хүсдэг.

ТАВ

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1 Бэлтгэх Ажил	10 минут	А. Сонголт Б. Хоол Хүнсний Пирамид В. Хүүхдүүдээ, Би Болох уу?	хуучин сэтгүүл, хайч, цаас, цавуу хоол хүнсний зураг (141-р хуудас) өнгийн харандаа
* Залбирал ба Магтаал*	10 минут	57-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал-ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2 Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	даавуун эсвэл цаасан бээлий, угааж болох өнгийн тодруулагч, уяа, сүлжмэл, тууз, олон өнгийн утас
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
3 Хичээлээ Заах	15 минут	Яг Зөв	хиймэл өндөг, жижиг цүнх, эсвэл жижиг сав, янз бүрийн эд зүйлсийн зураг
4 Хичээлээ Хуваалцах нь	15 минут	Сайн Сонголтын Таних Тэмдэг	тэмдэгний загвар (141-р хуудас) хатуу цаас, өнгийн харандаа, хайч, нэхмэлийн утас, уяа эсвэл тууз

Багшийн Баяжуулалт

"Хиймэл шүтээнд өргөсөн өргөл, хааны ширээнээс өгч байсан зоог нь Вавилоны шүтээний өргөл мэт тооцогддог байжээ. Хүндэтгэл ёсоор, Жэховагийн хаан Даниел болон түүний нөхдийг хамтдаа суухыг урьжээ. Дарс ууж, зоогны өчүүхэн хэсгээс идвэл л энэ нь тэдний итгэлийг үгүйсгэх байлаа. Үүнийг хийх нь ... Их Эзэний хуулийг зөрчсөн болно. (Зөнчид ба Хаад, х. 481).

"Өнөөдөр хүмүүс ямар ч алдаа гаргадаггүй Их Эзэний сорилтоор шалгагдан байдаг. Тэд бүгд өөрсдийн хэрхэн амьдрахаа сонгож байгаа бөгөөд Их Эзэн тэр бүгдийг өөрийн төлөвлөгөөндөө ашиглаж байдаг". (Зөнчид ба Хаад, х. 536).

Өрөөний Зохион Байгуулалт

Хоёрдугаар хичээлийн "Хааны өрөө"-г дахин ашиглаарай.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.



Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Сонголт

Хэрэгтэй зүйлс:

- хуучин сэтгүүлүүд
- хайч
- цаас
- цавуу

Цаасныхаа голоос тэгш зураас татахад нь хүүхдүүдэд туслан сайн болон муу сонголт хийж байгаа хүмүүсийн зургийг сэтгүүлээс хайчлуулан цаасан дээр наалгаарай.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах цаг өгөөрэй. Асуух: **Сайн болон муу сонголт хийж байгаа хүмүүсийг та нар олж чадав уу? Аль нь хийхэд амархан байна вэ? Та нар сайн сонголт хийхийг хүсэж байна уу?**

Их Эзэн биднийг үргэлж сайн сонголт хийхийг хүсэж байдаг. Учир нь бид сайныг сонгосноороо Их Эзэнтэй улам ойр болж чаддаг. Биднийг сайн сонголт хийхэд Есүс үргэлж туслахыг хүсэж байдаг. Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол ямар хоол идэхээ сайн сонгож чадсан дөрвөн залуугийн тухай юм. Өнөөдрийн хичээлийн гол утга санаа бол:



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Хоол Хүнсний Пирамид

Хэрэгтэй зүйлс:

- хоол хүнсний зураг (141-р хуудас)
- өнгийн харандаа

Хоол хүнсний загвар зургийг (141-р хуудас) болон өнгийн харандааг хүүхэд бүрт өгөөрэй. Зурган дээр байгаа хоол хүнсийг хүүхдүүдээр будуулаарай. Хэлэх: **Та нар өмнө нь ийм зүйл харж байсан уу? Энэ бол хоолны пирамид. Та нар пирамид гэж юу болохыг мэдэх үү? Пирамид нь гурвалжин хэлбэртэй, ёроол хэсэг нь хамгийн том бас суурь болдог. Энэ пирамид нь бидэнд ямар хоол хамгийн шим тэжээлтэй болон биднийг хэр зэрэг хэмжээтэй идэхийг хэлж өгөх болно. Янз бүрийн хоолны тухай болон өдөрт хэдэн удаа хэр зэрэг идэх тухай ярилцаарай.**

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Хамгийн дуртай хоол чинь юу вэ? Энэ хоолны пирамид дээр байна уу? Энэ нь чамайг энэ хоолыг бага ид гэсэн үг үү? Их ид гэсэн үг үү? Шим тэжээлтэй хоол идэх тийм**

чухал гэж үү? Есүс биднийг эрүүл байгаасай гэж хүсдэг үү?

Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол хоолоо зөв сонгож чадсан дөрвөн залуугийн тухай юм. Биднийг зөв сонголт хийхэд Есүс баяртай байдаг учир нь тэгснээрээ бид Түүнтэй улам ойр болдог. Өнөөдрийн гол утга санаа бол:



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

Намайг дагаад хэлээрэй.

В. Хүүхдүүдээ, Би Болох уу?

Энэ нь "Ээжээ, би болох уу?" гэдэг тоглоом шиг бөгөөд хүүхдүүдийг арын хананы эсрэг харуулан зогсоох буюу өөрөөсөө хол зогсоож болно.

Хэлэх: **Би янз бүрийн зүйл хийхдээ та нараас зөвшөөрөл авах болно. Зарим нь надад сайн ба зарим муу зүйл байгаа. Хэрвээ хийхэд сайн зүйл байвал та нар "Тийм ээ, та хий" гэж хэлэх ба хийхэд муу зүйл байвал "Үгүй ээ, хийж болохгүй" гэж хэлээрэй. Одоо давтаж үзье. Би та нараас "Хүүхдүүд ээ, би ээжийгээ цохиж болох уу?" гэхэд та нар "Үгүй ээ, та тэгэж болохгүй" гэх ёстой. Хүүхдүүд ээ, намайг дагаад хэлээрэй. Би "Хүүхдүүд ээ, би Библи уншиж болох уу?" гэж асуухад та нар "Тиймээ, та хий" гэж хэлээрэй. Намайг дагаад хэлээрэй.**

Тийм гэж хариулах болгондоо та нар нэг алхам урагшил. Үгүй гэж хэлэх бүртээ хойшоо нэг алх. Хүүхдүүд танд ойртон иртэл та тоглоомоо үргэлжлүүлээрэй. Тэгээд **"Хүүхдүүд ээ, би та нарыг тэвэрч болох уу?"** гэж асуугаад тэднийг тэврээрэй.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах цаг өгөөрэй. Асуух: **Энэ тоглоомын юунд нь та нар дуртай байсан бэ? Надад юу хийхийг минь хэлж өгч байсан болохоор дуртай байсан уу? Их Эзэн тэгвэл тийм биш. Тэр биднээр сонголт хийлгэдэг.**

Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол эрүүл мэнддээ хэрэгтэй хоол хүнс болон эрүүл мэндэд хортой дарс болон хоолноос сонголт хийх болсон дөрвөн залуугийн тухай юм. Бид сайныг сонгоход Их Эзэн баяртай байдаг бөгөөд учир нь энэ нь биднийг Их Эзэнтэй улам ойр болгож байдаг. Өнөөдрийн гол санаа:



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

Намайг дагаад хэлээрэй.



ТЭМДЭГЛЭЛ: Залбирал ба Магтаал 57-р хуудсанд бий.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- даавуун болон резин бээлий
- угааж болох тодруулагч
- уяа, нэхмэлийн утас,
- олон өнгийн утас
- тууз

Хүүхэд бүрт резин эсвэл даавуун бээлий өг. Бээлийний хуруу бүр дээр хүүхдүүдээр жирийн нэг нүүр зуруул. Эрхий хуруу нь хаан ба Мэлзар, долоовор хуруу нь Даниел, нөгөө гурван хуруу Даниелын гурван найз болог. Та өөртөө ч мөн нэгийг хийгээрэй.

Хэрвээ бээлийн дээр зурах нь хэцүү байвал ямар нэгэн угаадаг будгаар хүүхдүүдийн нэг гарын хуруунууд дээр зурж өг. Эсвэл уяа, нэхмэлийн утас, резин, зэрэг олон өнгийн зүйлийг өөр өөр дүр төрхийг илэрхийлэхээр хэрэглээрэй.

Хэлэх: **Өнөөдрийн түүхээ бид ярих гэж байна. Одоо бүгдээрээ түүхийн бээлийгээ**

өмсөөд эхэлцгээе. Хүүхдүүдэд аль хуруу нь хэн болохыг хэлээд түүхээ ярьж байхдаа өөрийнхөө хийж буй хөдөлгөөнийг дагахыг хэлээрэй.

Түүх ярих эвэл уншиж өгөх

Даниел болон түүний нөхөд ихэд ядарсан байв. [Эрхий хуруугаа гартаа үлдээн дөрвөн хуруугаа гозойлгох]. Мөн тэд ихэд гунигтай байлаа. [дөрвөн хуруугаа гозойлгох]. Тэд Вавилоны хаан Небухаднезарт баривчлагдсан ажээ. [Эрхий хурууг гозойлгох]. Тэр тэдэнд олон зүйл зааж өгөхөөр ордондоо авчруулав. [Эрхий хуруу 4 хурууг дарах ба хурууг машр алхуулах маягтай хөдөлгөө]. Тэднийг усанд орж шинэ хувцас өмссөний дараа хааны зарц Мэлзар [Эрхий хурууг дээш доош нь хөдөлгөх] "Зоог бэлэн боллоо" гэнэ.

Даниел болон түүний нөхөд зоогийн өрөөнд ороод [дөрвөн хуруугаа гозойлгох] ширээн дээр олон янзын амттай хоол байхыг харав.

Гэвч Даниел болон түүний нөхөд бие бие рүүгээ ихэд гунигтай харан [хуруунууд нугдийх] Их Эзэний тэдэнд

зөвшөөрөөгүй хоол байгааг харжээ. [Эрхий хуруу нугалаастай, 4 хуруу гозойж хойш урагш үгүй гэж байгаа маягтай хөдлөх].

Тэгээд Даниел [Долоовор хуруугаа хөдөлгөх] хааны зарц Мэлзараас [Эрхий хуруугаа гаргах] "Би болон манай найз нар [гурван хуруугаа гозойлгох] идэж байсан хоолоо л идэж болох уу? Их Эзэний бидэнд идэхийг зөвшөөрсөн хоол?" гэж асуухад Мэлзар [эрхий хурууг гаргах] Даниелд сайн байсан ч Даниелын санааг зөв гэж бодсонгүй. Тэгээд "Хаан та нарыг өөрийнхөө хоолноос идэхийг хүссэн. Хэрвээ та нар тураад ядарвал тэр намайг ажлаа хийсэнгүй хэмээн буруушаах болно" гэж Мэлзар хэлэв.

Даниел бодож байгаад "Тэгвэл биднийг арав хоног туршаад үз. Бидэнд зүгээр л жимс болон ногоо, самар будаа өгөөч. Тэгээд дарсны оронд ус өгөөч. Тэгээд арван өдрийн дараа бидний ямар болохыг харцгаа" гэв.

Мэлзар [эрхий хуруугаа дохиж] зөвшөөрч, арван хоногийн дараа Даниел болон түүний найз нар ихэд эрүүл саруул харагдаж байв. [дөрвөн хурууг дасгал хийж байгаа мэт хөдөлгөх]. Хааны ширээнээс идэж ууж байсан олзны хүмүүсээс тэд хамаагүй хүчтэй эрүүл чийрэг харагдаж байв. Хааны зарц Мэлзар [эрхий хурууг хөдөлгөх] Даниелыг зөв сонголт хийснийг нь мэдлээ. Тэгээд тэднийг хүссэн хоолоо идэж байхыг зөвшөөрөв. [Мэлзар хуруу дохиж].

Даниел болон түүний найз нарыг [дөрвөн хуруугаа гозойлгох] Их Эзэн Небухаднезар хааны ордонд Бурхан Эзэн ивээлээ. Тэр тэднийг Небухаднезар сургуульд сурахад нь тусалж Небухаднезар хаан тэднээс юу сурсныг нь асуухад тэд бусад олзлогдсон хүмүүсээс илүүтэйгээр мэдэж байв.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай. Асуух: **Даниел болон түүний нөхөд ямар сонголт хийсэн бэ? Тэд зөв сонголт хийсэн үү эсвэл буруу сонголт хийсэн үү? Даниел болон түүний нөхөд Мэлзараас өөр төрлийн хоол асуухаасаа айж байсан уу? Тэдэнд хэн тусалсан бэ? Тэдний сонголт Их Эзэнийг баярлуулсан болов уу? Даниел болон түүний нөхдөд Их Эзэн хэрхэн тусалсан бэ?**

Даниел болон түүний нөхөд Их Эзэний үгийг дагаж сайн хоол идэх эсвэл хааны үгийг дагаж шим тэжээлгүй хоол идэхийн аль нэгийг сонгох хэрэгтэй болдог. Хэрвээ бид Их Эзэний үгийг дагавал тэр нь Их Эзэнийг хүндэлж буй хэрэг юм. Хичээлийнхээ гол санааг санаж байна уу? Хамтдаа хэлцгээе:



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

(Story glove idea adapted from Saving Your Sanity: A Creative System for Teaching Preschoolers [Loveland, Colo.: Group Publishing, 1997], pp. 84, 85.)

Библи Судлал

Хэрэгтэй зүйлс:
 Библи

Библиэ нээгээд Даниел номын 1-р бүлгийг гаргаад **"Өнөөдрийн бидний үзэх түүх Библийн маань энэ хэсэгт**

байна" гэж хэлэн ишлэлүүдийг чангаар уншаарай.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай. **Даниел болон түүний нөхөд баригдсаныхаа дараа хаана очсон бэ? Хаан тэднийг юу идэж уухыг хүссэн бэ? Даниел болон түүний нөхөд юу идэхийг хүссэн бэ? Тэдний туршилтын хугацаа хэр удаан байсан бэ? 10 хоногийн дараа тэд ямар харагдаж байв? 3 жилийн дараа тэд хааны шалгалтаар ямар байсан бэ? Та нар Даниел болон түүний нөхөд шиг зөв сонголт хийхийг хүсэж байна уу? Гол санаа:**



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

Намайг дагаад хэлээрэй.


Цээжлэх Ишлэл

Библиэ нээгээд Исаиа 7:15-г гарган **"Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна"** гэж хэлээд ишлэлийг чангаар уншаарай. **"Бурууд татгалзаж зөвийг сонго"** гээд цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.

Хэрэгтэй зүйлс:
 Библи

Бурууд татгалзаж

Толгойгоо сэгсрээд муухай харах.




зөвийг сонго.

Толгойгоо дохиод инээмсэглэх.



Исаиа 7:15

Алгаа ном мэт дэлгэнэ.



3

Хичээлээ Заах

Яг Зөв

Хэрэгтэй зүйлс:

- хиймэл өндөг
- жижиг цүнх эсвэл жижиг савнууд
- янз бүрийн зураг эсвэл эд зүйлс

Ангийнхнийгаа ирэхээс өмнө, зугаалгаар явж буй зураг, амьтад болон байгалийн зураг, хуурцаг, спортоор хичээллэж буй зураг, Библийн сургуулийн амралтын зураг, Есүсийн зураг, чихэр, самар, хутга, буу, архи, тамхи, Библи, тоглоом, хүнсний ногоо, жимс гэх мэт сайн болон мууг төлөөлсөн зүйлүүдийг жижиг савнууд юмуу цүнхэнд хийгээрэй.

Тэгээд хүүхдүүдийг ирэхэд нуусан цүнх эсвэл савнуудаа хүүхдүүдээр олуулан онгойлгохгүйгээр олсон зүйлээ авчран суудалдаа суухыг нь хэлээрэй.

Хүүхдүүд суудалдаа ирж суусны дараа "Одоо цүнхээ онгойлгоод юу юу байгааг нь ангийнхандаа харуулаач. Хэрвээ ямар нэгэн сайн зүйл байвал та нар "Тийм ээ, Бид ивээгдэх болно" гэж хэлэх ба ямар нэгэн муу зүйл олдох үед "үгүй, үгүй, бид үүнийг авахгүй" гэж хэлэх хэрэгтэй. Одоо бүгдээрээ давтаж үзье.

Бататгах нь

Хариулах цаг гаргаарай: **Ямар нэгэн зүйлийг чамд сайн эсвэл муу гэдгийг яаж мэдэх вэ? Сайн зүйл хийхэд тийм гэж хэлэх нь мөн муу зүйл хийхэд үгүй гэж хэлэх нь яагаад чухал вэ? Зөв сонголт хийхэд амархан байдаг уу? Хэрвээ хэн нэгэн найз чинь буруу сонголт хийвэл яах вэ? Та нарыг хүч чадалтай байхад болон муу зүйл рүү татагдахгүй байхад хэн тусалдаг вэ?**

Зөв сонголт хийх нь чиний биеийг эрүүл саруул байлгадаг. Зөв сонголт чиний оюун ухааныг цэвэр ариун байлгах болно. Хэрвээ бид буруу сонголт хийвэл тэр нь биднийг Их Эзэнээс холдуулдаг. Муу зүйл нь Есүсийг гунигтай болгох зүйлүүдийг биднээр хийлгэж бодуулж, яриулж байдаг.

Хийсэн сонголтоороо та нар Их Эзэнийг алдаршуулж хүндлэхийг хүсч байна уу? Дараа чамд сонголт хийх хэрэг гарвал Даниел болон түүний найз нарын хийсэн зүйлийг санаад чамд хэрэгтэйг нь сонгож байгаарай. Хичээлийнхээ гол санааг хамтдаа хэлцгээе:



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

4

Хичээлээ Хуваалцах нь

Зөв Сонголтын Таних Тэмдэг

Хатуу цаасан дээр 141-р хуудсыг харж байгаад таних тэмдэгний загвар хийж цаасан дээрээ нүх гаргаад хүүхэд бүрт өг. Хүүхдүүдээр таних тэмдгийг будуулж нүхлэсэн нүхээр нь уяа оруулан уяж хүзүүнээс зүүгээрэй.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Чиний таних тэмдэг ямар угтатайг мэдэх үү? Та нар таних**

тэмдгээ зүүгээд уулзсан хүмүүстээ харуулж болно. Хэрвээ тэд чамаас тэмдэгний чинь тухай асуувал тэдэнд Даниел болон түүний найз нарын тухай ярьж өгөөрэй. Энэ долоо хоногийн захиас үг:



Зөвийг сонгосноороо бид Их Эзэнийг алдаршуулдаг.

Хэрэгтэй зүйлс:

- таних тэмдэгний загвар (х. 141)
- хатуу цаас
- өнгийн харандаа
- хайч
- уяа, нэхмэлийн угас, тууз

Хичээлийн Хаалт

Энэ долоо хоногт хүүхдүүд зөв сонголт хийхийн төлөө Их Эзэнд хандан залбираарай.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нөхөрлөл

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох Дуунууд

"Сонголт хийхэд минь Есүс тусалдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 304*)

"Өнөөдөр цаг нь" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 238*)

"Хөгжимдөх нь" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 220*)

"Халлелүяа, Халлелүяа" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 213*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс тохирох түүх сонгож аваарай.

Хандив

Хэлэх: **Бусдад зориулан хандив өргөснөөрөө бид Их Эзэнийг алдаршуулдаг.**

Залбирал

Тойргоор ээлжлэн залбираарай. Дуртай хоолныхоо төлөө Их Эзэнд талархахыг нь хүүхэд бүрт сануулж сайн хоол өгсөнд нь Их Эзэнд талархаад залбирлаа дуусгаарай.

* Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

Сорилтыг Давах нь

Унших Зүйл

Даниел 1;
Зөнчид ба Хаад
479-490.

Цээжлэх Ишлэл

"Бурууд
татгалзаж зөвийг
сонго" (Исаиа
7:15).

Гол Санаа

Зөвийг

сонгосноороо бид
Их Эзэнийг
алдаршуулдаг.

Таны дуртай хоол юу вэ? Бас ямар дуунд дуртай вэ? Энэ бүхэн таны хувьд зөв сонголт уу? Даниел болон түүний нөхөд зөв сонголт хийсэн юм.

Даниел болон түүний гурван найз ихэд ядарсан байв. Тэд явсаар гайхалтай сайхан ордонд ирлээ. Тэд Вавилоны хаан Небухаднезарт олзлогдсон учир ихэд гунигтай байлаа. Тэд харийн нутагт танихгүй хүмүүсийн дунд ирсэн байлаа. Тэр тэдэнд олон зүйл зааж өгөхөөр ордондоо авчруулсан байв. Тэднийг усанд орж шинэ хувцас өмссөний дараа хааны зарц Мэлзар "Зоог удахгүй бэлэн болно" гэлээ. Даниел болон түүний нөхөд өрөөндөө орж ирээд орныхоо өмнө өвдөглөн сууцгаав. Тэд өөр улс оронд, танихгүй хүмүүсийн дунд тэдний Эзэн Бурханд залбирдаггүй хүмүүсийн дунд зөв сонголт хийж бэрхшээлийг даван туулах хүч чадал хайрлаасай гэж Эзэнд хандан залбирцгаалаа.

Удалгүй хоол бэлэн болж Даниел болон түүний нөхөд зоогийн өрөөнд ороод ширээн дээр олон янзын амттай хоол байхыг харав. Ширээн дээр маш олон амттан тансаг идээ дүүрэн өрсөн байлаа. Энэ бүгд хааны ширээн дээрээс ирсэн хоол байлаа. Энэ хоолыг шүтээнд тахил болгосон байв.

Гэвч Даниел болон түүний нөхөд бие бие рүүгээ ихэд гунигтай харан Их Эзэний тэдэнд зөвшөөрөөгүй хоол байгааг харжээ. Тэгээд яах билээ гэж бие бие рүүгээ харцгаав.


Тэгээд Даниел хааны зарц Мэлзараас "Би болон манай найз нар өмнө нь идэж байсан хоолоо л идэж болох уу? Их Эзэний бидэнд идэхийг

зөвшөөрсөн хоолыг идэж болох уу?" гэж асуухад Мэлзар Даниелд сайн байсан ч Даниелын санааг зөв гэж бодсонгүй. Тэгээд "Хаан та нарыг өөрийнхөө хоолноос идэхийг хүссэн. Хэрвээ та нар тураад ядарвал тэр намайг ажлаа хийсэнгүй хэмээн буруушаах болно" гэж Мэлзар айсан аястай хэлэв.

Даниел бодож байгаад "Тэгвэл биднийг арав хоног туршаад үз. Бидэнд зүгээр л жимс ногоо, самар будаа өгөөч. Тэгээд дарсны оронд ус өгөөд арван өдрийн дараа бидний ямар болохыг харцгаа" гэв.

Мэлзар зөвшөөрлөө. Ингээд арван хоногийн турш хөвгүүдэд хүссэн хоолыг нь өгөөд дараа нь Даниел болон түүний найз нар ихэд эрүүл саруул харагдаж байв. Хааны хоолноос идэж ууж байсан бусад олзны хүмүүсээс тэд хамаагүй хүчтэй эрүүл чийрэг харагдаж байв. Хааны зарц Мэлзар Даниелыг зөв сонголт хийснийг нь мэдлээ. Тэгээд тэднийг хүссэн хоолоо идэж байхыг зөвшөөрөв.

Даниел болон түүний найз нарыг Их Эзэн Небухаднезар хааны ордонд ивээлээ. Тэр тэднийг Небухаднезарын сургуульд сурахад нь тусалж Небухаднезар хаан тэднээс юу сурсныг нь асуухад тэд бусад олзлогдсон хүмүүсээс илүүтэйгээр мэдэж байсан төдийгүй улсын бүх ухаантан мэргэдээс ч тэд илүү ухаантай байлаа. Тэд гаргасан сонголтоороо дамжуулан Бурханыг алдаршуулсан юм. Чи ч бас ингэж чадна.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

Бурууд татгалзаж ..Толгойгоо сэгсрээд муухай харах.

зөвийг сонгоТолгойгоо дохиод инээмсэглэх.


Исаиа 7:15.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

Дэлгүүрт ороод хүүхэдтэйгээ хоол хүнсээ зөв сонгох тухай ярилцаарай. Хөргөгч

болон хоолны шүүгээ рүүгээ харж жимс, будаа, самар,

хүнсний ногоо гэх зэргийг заахад нь хүүхдэдээ туслаарай.



Даваа

Шаббат хичээл дээр хийсэн "Надаас зөв сонголтын тухай асуу" гэсэн таних тэмдгийг хэн нэгэнтэй хуваалцаж тэдэнд Даниел болон өөрийнх нь сонголтын тухай ярихад нь урамшуулаарай. Эсвэл дугуй цаасан дээр таних тэмдэг хийж зурахад нь туслаад цаасыг нүхлэн утас уяж хүзүүндээ зүүхэд боломжтой болгож өгөөрэй.

Мягмар

Зөв зүйл сонгож байгаа хүмүүсийн зурагтай сонин сэтгүүл хараад "Чи өдөр бүр


ямар сонголт хийдэг вэ? (үгэнд орох болон орохгүй байх, найрсаг байх болон хатуу ширүүн байх, телевизээр юу үзэхээ сонгох гэх мэт.) Чи зөв сонголт хийж чаддаг уу?" гэж асуугаад сонголтынхоо төлөө Есүст талархаарай.

Лхагва

Өчигдөр ямар хоол идсэнээ санахад нь хүүхдэдээ туслан, өдөр бүр хэр зэрэг будаа болон жимс иддэгийг нь тоолуулаарай. Гэр бүлийнхнийхээ хийсэн хоолны зөв сонголтын тухай ярилцаад маргаашийн хоолоо хүүхдээрээ сонгуулаарай.

Пүрэв

Сонголт хийж болох зүйлийг нэрлээд (өглөөний цай, унших ном, телевизийн хөтөлбөр гэх мэт) заримдаа бидэнд хоёр сонголт байдгийн хоёулаа зөв байдаг ч нэг нь илүү сайн байдаг гэж хэлж өгөөрэй.



Баасан

Шаббат өдрийн онцгой зоогт зориулж хүүхдээрээ дэлгүүрээс сонголт хийлгэж хоол хийхдээ туслуулаарай.

Гэр бүлтэйгээ хамтран Библийн түүхийг жүжиглээд "Даниел болон түүний найз нар ямар хоол сонгосон бэ? Арван өдрийн дараа тэд ямар харагдаж байсан бэ? Их Эзэн тэдэнд тусалсан уу? Зөв сонголт хийхэд үргэлж амархан байдаг уу? Хэрвээ найз чинь буруу сонголт хийвэл чи яах вэ?" гэж асуугаарай.